



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/18/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг</p> <p>Утас:261663Цахим хаяг:<a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням: Утас:260949Цахим хаяг:<a href="mailto:sambuunyamya@audit.gov.mn">sambuunyamya@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас:261885 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: А.Даваадорж Утас:261628 Цахим хаяг: <a href="mailto:davaadorja@audit.gov.mn">davaadorja@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Г.Мөнхчимэг Утас:261628 Цахим хаяг:<a href="mailto:munkhchimegg@audit.gov.mn">munkhchimegg@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Хавсралт..... 15

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,042,847.3	1,704,751.3
35	БАРАА МАТЕРИАЛ	1,042,847.3	1,704,751.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	216,753.2	2,317,178.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	216,753.2	2,317,178.8
39200	Биет хөрөнгө	186,405.8	2,259,580.8
39300	Биет бус хөрөнгө	30,347.4	57,598.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,259,600.5</b>	<b>4,021,930.1</b>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,259,600.5	4,021,930.1
51	Засгийн газрын хувь оролцоо	1,259,600.5	4,021,930.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,410,826.1	14,410,826.1
51200	Хуримтлагдсан үр дүн	(13,152,437.1)	(10,390,145.2)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,211.5	1,249.2
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,259,600.5</b>	<b>4,021,930.1</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,083,985.2	41,050,387.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,954,682.9	2,940,455.9
120	Нийтлэг татварын бус орлого	3,954,682.9	2,940,455.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,954,682.9	2,940,455.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,129,302.3	38,109,931.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,259,912.9	38,288,057.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,305,377.5	38,288,057.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,101,052.3	37,318,153.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,170.0	591,176.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,255.2	74,111.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,130.0	6,982.3
2104	Хангамж, бараа материалын зардал	145,070.7	154,611.4
2107	Томилолт, зочны зардал	3,750.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	265,149.3	229,928.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,527.1	36,261,343.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	204,325.2	969,904.6
222001	Хаагдсан данс	3,954,535.4	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,824,072.3	2,762,329.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,933,230.4	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(109,158.1)	2,762,329.6

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,368,758.6		1,368,758.6
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,368,758.6		1,368,758.6
3	Тайлант үеийн үр дүн	(109,158.1)		(109,158.1)
4	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,259,600.5		1,259,600.5
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,259,562.8		1,259,562.8
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(37.7)		(37.7)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,259,562.8		1,259,562.8
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	37.7		37.7
9	Тайлант үеийн үр дүн	2,762,329.6		2,762,329.6
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,021,930.1		4,021,930.1

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,129,449.8	38,109,931.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147.5	-
120	Нийтлэг татварын бус орлого	147.5	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,129,302.3	38,109,931.3
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,129,302.3	38,109,931.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,130,665.6	38,096,515.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,130,665.6	38,096,515.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,340.4	37,126,611.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,170.0	591,176.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,255.2	74,111.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,130.0	6,982.3
2104	Хангамж, бараа материалын зардал	44,459.6	34,133.2
2107	Томилолт, зочны зардал	4,100.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	265,149.3	230,578.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,076.3	36,189,629.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	204,325.2	969,904.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,998,784.2	13,415.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,998,784.2	13,415.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,998,784.2	13,415.5
2200	Дотоод эх үүсвэрээр	3,998,784.2	13,415.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,998,784.2)	(13,415.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,109,931.3	37,270,514.8	839,416.5	97.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,109,931.3	37,270,514.8	839,416.5	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,979,441.2	37,140,026.7	839,414.5	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,951.0	591,176.5	14,774.5	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,803.5	74,111.8	7,691.7	90.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,638.5	6,982.3	1,656.2	80.8
2104	Хангамж, бараа материалын зардал	34,495.4	34,133.2	362.2	98.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,000.0	-	350,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,834.2	230,578.0	256.2	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,667,718.6	36,203,045.0	464,673.6	98.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,490.1	130,488.0	2.1	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	29,700.0	29,698.0	2.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,790.1	100,790.1	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	38,109,931.3	37,270,514.8	839,416.5	97.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,109,931.3	37,270,514.8	839,416.5	97.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	72	72	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35	35	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35	35	-	100.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Г.Мөнхчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 03/50 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сонгуулийн ерөнхий хорооны зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд: “Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах, сонгуулийн хороодыг нэгдсэн удирдлагаар хангах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах эрхтэй төрийн байгууллага мөн” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон дараах хуулиуд байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг MNS 6817-4: 2020 стандартын дагуу тодорхойлохдоо суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн урсгал зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны батлагдсан төсвийн урсгал зардал 38,288.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 765.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,762.3 сая төгрөгөөр өсөхөд бараа материал, үндсэн хөрөнгийн дансны өөрчлөлт нөлөөлсөн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	1,042.8	1,704.8	661.9
Үндсэн хөрөнгө	216.8	2,317.2	2,100.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,259.6</b>	<b>4,021.9</b>	<b>2,762.3</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,259.6	4,021.9	2,762.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,259.6</b>	<b>4,021.9</b>	<b>2,762.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 1,704.8 сая төгрөг болж 661.9 сая төгрөгөөр өссөн нь УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад сонгуулийн автоматжуулсан системд ашигладаг бараа материал бэлтгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2001-2008 онд худалдаж авсан ашиглалтгүй 2.0 сая төгрөгийн аж ахуйн зориулалттай бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,317.2 сая төгрөг болж 2,100.4 сая төгрөгөөр өссөн нь Сонгуулийн автоматжуулсан системтэй холбоотой санал тоолох ICP төхөөрөмж, программ хангамжийн лиценз худалдан авсан, мөн зарим техник хэрэгслийг шинэчилснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн хөрөнгийн худалдан авалтын 13.4 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 2,198.7 сая төгрөг, нийт 2,212.1 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан 164.4 сая төгрөгийн хөрөнгөөр хорогдсон байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,021.9 сая төгрөг болж 2,762.3 сая төгрөгөөр өссөн нь ээлжит сонгуулийг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд санал тоолох ИСР төхөөрөмж болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамж, тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1,249.2 мянган төгрөг болж 37.7 мянган төгрөгөөр өсөхөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/395 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны даргын 2020 оны А/05 дугаар тушаалаар 57,500.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан нь нөлөөлжээ.

Хуримтлагдсан үр дүн 2,762.2 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан нь УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой сонгуулийн зардлын төсөв нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг 43,714.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 5,572.8 сая төгрөгөөр бууруулж 38,141.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь УИХ-ын ээлжит сонгуулийн зардлыг 3,380.0 сая төгрөг, Орон нутгийн сонгуулийн зардлыг 1,914.3 сая төгрөг, бусад зардлыг 278.4 сая төгрөгөөр тус тус бууруулсантай холбоотой байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Монгол Улсын төсвөөс 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардлын хэмжээг 38,141.3 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 31.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 7 арга хэмжээнд шаардлагатай 38,109.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн зардалд 20,495.6 сая, ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн зардалд 16,505.3 сая, урсгал үйл ажиллагааны зардалд 1,109.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийтдээ 38,109.9 сая төгрөгийн санхүүжилт авч, 37,270.5 сая төгрөг буюу 97.8 хувийг зарцуулж, улсын төсөвт 839.4 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн дутуу зарцуулалт дараах зардлуудын гүйцэтгэлтэй холбоотой байна. Үүнд:

- Бүх шатны сонгууль зохион байгуулахад сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, заавар боловсруулах, маягт бэлтгэх зардлын төсвийг 34.9 сая төгрөгөөр,
- Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах, сургалт семинарын зардлын төсвийг 130.1 сая төгрөгөөр,
- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх зардлын төсвийг 166.5 сая төгрөгөөр,
- Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд хяналт тавих зардлын төсвийг 11.3 сая төгрөгөөр,

- Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагааг хангах, программ хангамжийн аюулгүй ажиллагааг хангах зардлын төсвийг 407.2 сая төгрөгөөр,
- Мэдээллийн бааз үүсгэх зардлын төсвийг 89.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн талаар:** Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн зардлыг 20,495.6 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн зардлын нийт гүйцэтгэл 19,805.9 сая төгрөг гарч, Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудитыг хийсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулахад нийт 11,056.6 сая төгрөгийн санхүүжилтийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд шилжүүлж, 10,970.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 86.2 сая төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны данс руу төвлөрүүлсэн байна.

Саналын хуудас хэвлүүлэх, санал тоолох, дүн гаргах, тээврийн зардал, төрийн сүлд, сонгуулийн хууль, заавар журмын эмхэтгэл, даамлын гарын авлага, заавар, сурталчилгааны шторк, плакат, нугалбар, сонгуулийн хороодын тэмдэг хийлгэх, нэг удаагийн лац, саналын хуудасны хавтас, дугтуй, зөөврийн саналын хайрцаг, сонгуулийн сурталчилгааны зардал, автоматжуулах систем хэрэглэхтэй холбоотой зардал зэрэгт нийт 8,835.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороод хууль, журамд заасны дагуу сонгуулийн зардлын тайландаа харьяа аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудаар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

**Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль:** Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны сонгуулийн ээлжит сонгуулийн төсвийг 16,505.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулахад нийт 10,897.2 сая төгрөгийн санхүүжилтийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод шилжүүлснээс 10,712.7 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 184.5 сая төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны данс руу төвлөрүүлсэн байна.

Тухайн сонгуулийг зохион байгуулахад УИХ-ын сонгуультай адил нэр төрлийн зардалд нийт 5,076.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороод хууль, журамд заасны дагуу сонгуулийн зардлын тайланг харьяа аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудаар аудит хийлгэж, баталгаажуулсан тайлангаа ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд гүйцэтгэлээр нийт 15,789.1 сая төгрөгийг зарцуулж, 716.2 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Сонгуулийн ерөнхий хорооны 2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 3 чиглэлийн 8

ажлаас 7 ажил нь бүрэн хэрэгжиж Сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянах арга хэмжээ хэрэгжээгүй нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1, 58.2 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллага сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд зарлахаар хуульд өөрчлөлт орсонтой холбоотой байна.

### **3.9 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 172 мэдээлэл байршуулахаас 168 мэдээллийг хугацаанд нь, хугацаа хоцроож 4 мэдээллийг байршуулсан байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 36.5 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

### **3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 80.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

##### **Балансын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн 80.1 сая төгрөгийн өртөгтэй авто тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байгаа нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

**Эрсдэл:** Тооллогын комисс ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлээгүй байх, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгийн дүнгээр балансын дансны үлдэгдэл нэмэгдэх;

**Өгсөн зөвлөмж:** Ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх;

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

**Хавсралт**

/сая төгрөг/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн 80.1 сая төгрөгийн өртөгтэй авто тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй байна.	80.1	Зөвлөмж	Ажлын албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч	Д.Баяндү үрэн, Ж.Оюунг эрэл
	<b>ДҮН</b>	<b>80.1</b>			